

БАТЛАВ:  
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА 3.ТҮВШИНТӨГС

**“ХОГГУЙ ЦЭВЭРХЭН СЭЛЭНГЭ-БИДНИЙ ИРЭЭДҮЙ” ЗАХИДЛЫН УРАЛДААНЫ  
УДИРДАМЖ**

**ЗОРИЛГО :**

1. Хог хаягдлын талаарх хүүхдүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтэд сурталчлах
2. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж гэртээ хөл хорионд байгаа сурагчдын идэвхийг нэмэгдүүлэх

**ХАМРАХ ХҮРЭЭ :** Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдид хамрагдана.

**ХУГАЦАА:**

2020 оны 06 сарын 22-ныг хүртэл хугацаанд сурагчид захидлынхаа зургийг сайтар нягтралтай фото аппарат, гар утсаар аван Сэлэнгэ аймаг Байгаль орчин аялал жуулчлалын газар гэсэн пэйж хаягаар болон [se.mne.gov.mn@gmail.com](mailto:se.mne.gov.mn@gmail.com) хаягаар ирүүлнэ.

**ТАВИГДАХ ШААРДЛАГА :**

- 1. 80-90 үгэнд багтаасан байх /1 нүүр/
- Гаргацтай, тодорхой бичих
- Гараар А4 цаасан дээр буюу дэвтрийн заасан дээр бичих
- Захианыхаа аль нэг буланд захидалтай холбоотой зургаар чимэх
- Сэлэнгэ аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар пэйж хуудсанд лайк дарж, шэйр хийсэн байх
- Захиа бичсэн сурагч овог нэр, нас, анги, сургууль, холбоо барих утасны дугаарыг захианы зүүн доод буланд бичсэн байх

**УРАЛДААНЫГ ДҮГНЭХ:**

Нийт ирсэн захидлуудаас шилдэг захидлуудыг Сэлэнгэ аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар пэйж хуудсанд нийтлэх бөгөөд хамгийн олон хандалт авсан, мөн шүүгчдээс өгсөн оноог нэгтгэн шагналт байрыг шалгаруулна.

**ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:**

- 1-р байр- өргөмжлөл, мөнгөн шагнал, Бикоши сав
- 2-р байр- өргөмжлөл, мөнгөн шагнал, Бикоши сав
- 3-р байр- өргөмжлөл, мөнгөн шагнал, Бикоши сав
- Тусгай байр-өргөмжлөл, Бикоши сав

*/Бикоши сав нь гэрийн нөхцөлд хүнсний хог хаягдлыг исгэн ялзмагжуулан бордоо болгоно/*

Дэлгэрэнгүй мэдээллийг 95126512 утсаар болон Сэлэнгэ аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар фэйсбүүк пэйжээр холбогдон авч болно.

БАТЛАВ:  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА 3.ТҮВШИНТӨГС

**“ХОГГҮЙ ЦЭВЭРХЭН СЭЛЭНГЭ-БИДНИЙ ИРЭЭДҮЙ” ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ  
УДИРДАМЖ**

**ЗОРИЛГО :**

“Хандлагаа өөрчилье” багц ажлын хүрээнд “Хоггүй, цэвэрхэн Монгол” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах, Хог хаягдлын талаарх хүүхдүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, зөв дадал хэвшлийг уриалах

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж гэртээ хөл хорионд байгаа сурагчдын идэвхийг нэмэгдүүлэх

**ХАМРАХ ХҮРЭЭ :** Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хамрагдана.

**ХУГАЦАА:**

2020 оны 06 сарын 22-ныг хүртэл хугацаанд сурагчид зурсан зургаа сайтар нягтралтай фото аппарат, гар утсаар аван Сэлэнгэ аймаг Байгаль орчин аялал жуулчлалын газар гэсэн пэйж хаягаар болон [se.mne.gov.mn@gmail.com](mailto:se.mne.gov.mn@gmail.com) хаягаар ирүүлэх

**ТАВИГДАХ ШААРДЛАГА :**

- Утга агуулга ойлгомжтой байх
- Гар зургийн бүх төрлөөр, А3 формат /42x29.7 см/дээр зурна.
- Уралдаанд оролцож буй сурагч овог нэр, нас, анги, сургууль, холбоо барих утасны дугаарыг зургийн зүүн доод буланд бичсэн байх

**УРАЛДААНЫГ ДҮГНЭХ:**

Зурсан зурагнуудыг Сэлэнгэ аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар пэйж хуудсанд нийтлэх бөгөөд хамгийн олон хандалт авсан, мөн шүүгчдээс өгсөн оноог нэгтгэн шагналт байрыг шалгаруулна.

**ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:**

- 1-р байр- өргөмжлөл, 200 000 мянган төгрөг, ном
- 2-р байр- өргөмжлөл, 100 000 мянган төгрөг, ном
- 3-р байр- өргөмжлөл, 80 000 мянган төгрөг, ном
- Тусгай байр-өргөмжлөл, 50 000 мянган төгрөг, ном

Дэлгэрэнгүй мэдээллийг 95126512 утсаар болон Сэлэнгэ аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар фэйсбүүк пэйжээр холбогдон авч болно.